

## Иргэний үнэмлэх захиалах

Written by Administrator

Thursday, 12 March 2015 15:56 - Last Updated Tuesday, 17 March 2015 14:43

---

2014 онд батлагдсан “Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, түүнд мэдээлэл оруулах, бүртгэл хотлох журам”-ын хүрээнд тус ЭСЯ-аар дамжуулж иргэний үнэмлэх захиалах, бүртгэх ажлыг эхлүүлээд байна.

Уг ажлын хүрээнд тус ЭСЯ Монгол Улсын 16 нас хүрсэн иргэнд шинээр иргэний үнэмлэх олгох болон иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгах, 25, 45 насанд иргэний үнэмлэхийг сольж олгох, иргэний үнэмлэхийн хүчинтэй байдлыг алдагдуулсан, гэсэн, үрэгдүүлсэн иргэдэд иргэний үнэмлэхийг дахин олгох вйлчилгээг эзүүлэх бөгөөд иргэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Гадаад паспортын хуулбар

2. Торсний гэрчилгээний хуулбар

3. Хуучин иргэний үнэмлэхийн хуулбар /Энэ заалт зөвхөн иргэний үнэмлэхийн хугацааг сунгуулах, 25, 45 насны дахин бүртгэлд хамрагдаж, үнэмлэх сольж авах хүмүүст хамаарна/

4. Эцэг, эхийн иргэний үнэмлэхийн хуулбар /Энэ заалт зөвхөн 16 нас хүрсэн, иргэний шинэчилсэн бүртгэлд анх удаа хамрагдах гэж буй иргэдэд хамаарна/

5. Тэмдэгтийн хураамж толсон баримт

- 16 нас хүрсэн иргэн шинээр иргэний үнэмлэх авах, иргэний үнэмлэхийн хугацааг сунгуулах, 25, 45 насанд иргэний үнэмлэхийг сольж авахад 300 швед крон.

## **Иргэний үнэмлэх захиалах**

Written by Administrator

Thursday, 12 March 2015 15:56 - Last Updated Tuesday, 17 March 2015 14:43

---

- иргэний үнэмлэхийг гэсэн, үрэгдүүлсэн бөгөөд дахин захиалах тохиолдолд торгуулийн хамт 550 швед крон .